

Судалгааны нэр: Төсөлт ажил
Илтгэлийн нэр: “Төсөлт ажил
хичээл-Хүүхдийн хөгжил

*Илтгэлийг бичсэн: Завхан аймаг
Тосонцэнгэл сумын Л. Цэндийн
нэрэмжит ЕБ-ын 1-р сургуулийн багш
Ж.Мөнгөнтуул, П.Норжмаа,
Х.Эрдэнэболор*

Ерөнхий танилцуулга

Хичээлийн санаа

Хичээлийн эхлэл хэсгийн шийдэл

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл

Хичээлийн төгсгөл хэсгийн шийдэл

Дүгнэлт, үр дүн, цаашид дэвшүүлэх санал

Ном зүй хавсралт



Ертөнцөд нэг ижил хоёр хүүхэд байхгүй. Хүн бүр сурах чадвар нөөц бололцоо ялгавартайг хүлээн зөвшөөрч хүүхэд төвтэй сургалт зохион байгуулах шаардлага зайлшгүй урган гарч ирсэн.

Хүүхэд орчин тойронтойгоо харьцах явцдаа мэдлэг олж авч бүтээх, алдаан дээрээ суралцан бусадтай хамтран хөгжих сурах эрмэлзэлтэй болдог. Ийм хичээлийн гол дүр хүүхэд байж хүүхдийн үйл ажиллагаанаас бүх зүйл шалтгаална. Багш ердөө хүүхдийн хөгжлийг дэмжигч, чиглүүлэгч болдог. Ийм шийдэлд хүрч чадах амьдралд ойр мөртлөө хүний хөгжилд бодитой чадвар олгодог Төсөлт ажлын судалгаат хичээлийг манай сургууль Здахь жилдээ амжилттай хэрэгжүүлээд байна.

ТА-ын сэдвийг

1. Нийгэм хүмүүсийн амьдрал, байгаль орчин эрүүл мэнд
2. Хүүхдийн сонирхол эрэлт хэрэгцээнд тулгуурласан сэдэв
3. Орон нутаг сургуулийн онцлогт тохирсон сэдэв гэж ерөнхийд нь 3 хэсэг багцалж болно.

Сурагчдын хэрэгцээ сонирхол амьдралд ойрхон, цаг үетэйгээ холбогдсон учраас сэдвээ сонгосон.

Хичээлийн гол санаа:

Сурагчид таван хошуу малын тухай тодорхой ойлголттой боловч ноос ноолуураар бүтээгдэхүүн хийх, арьс ширийг боловсруулж эдлэл хийх, сүүг хэрхэн боловсруулж ааруул эзэгий хийх аргуудыг сайн мэдэхгүй учир гүнзгийрүүлэн судалж мэдэх болсон.

Хичээлийн бэлтгэл судалгаанд: багш Баярмаа, Биологийн багш П.Норжмаа, Англи хэлний багш Х.Эрдэнэболор, багш Мөнгөнтуул, Долгорсүрэн, Баянзул нар хамтран хийсэн.

2013 оны 04 сард явагдсан Жайкагийн мониторингийн үед судалгаат хичээлийг Тосонцэнгэл сумын ЕБ-ын 1-р сургуулийн 5А ангид бага ангийн багш Баярмаа заалаа.

Хичээлийн бэлтгэл судалгаа

Сурагчдын өмнөх
төсөөлөл

- Таван хошуу малын тухай ерөнхий ойлголт

Алдааны судалгаа

- Мэдээлэлийг олон сувгаар цуглуулах, боловсруулалт хийх
- Сонгосон сэдвээсээ халих, давхцах
- Гол зүйлээ олохгүй байх

Судлагдахууны судалгаа

- Багуудад судлах зүйлийг чиглүүлж өгөх
- Төлөвлөлтөнд анхаарах
- Уншиж судлах номын нэр, хуудас, мөн уулзаж ярилцах хүмүүсийн нэр хаягийг хэлж өгөх

Арга зүй

- Асуудал дэвшүүлэн шийдвэрлүүлэх
- Бие даан бүтээлчээр мэдэх, харилцан ярилцах
- Хүүхдийн насны онцлогийг харгалзан тэдний сонирхолыг төрүүлэх

Хэрэглэгдэхүүний
судалгаа

- Сэдэлжүүлэх бичлэг
- Слайдаар сурагчдыг чиглүүлэн идэвхжүүлэх
- Хүүхдүүдийн цуглуулсан мэдээлэлээр орчин бүрдүүлэх

Мэдлэг эзэмшилтийн
хувьд

- Сурагчдын бие даан ажиллах чадвар
- Хоорондын эерэг харилцаа
- Сурах хүмүүжих төлөвших

Үнэлгээний хувьд

- Тайлангийн явцад багш сурагчдын оролцоо, илтгэх чадвар, ахиц өөрчлөлт зэргийг өөрийн тэмдэглэл дээр хөтөлж өөрчлөлтийг олж харах
- Стандарт бус үнэлгээ

Хичээлийн эхлэл хэсгийн шийдэл:

Хичээл эхлэхийн өмнө сурагчид 4 багт хуваагдан суусан. Ангийн сурагчид нь “Таван хошуу малын ашиг шим” ерөнхий сэдвийн дор

-Сүү, сүүн бүтээгдэхүүн

-Мах, махан бүтээгдэхүүн

-Арьс шир

-Ноос ноолуур гэсэн 4 дэд сэдвээр баг тус бүр сэдвийн тор үүсгэж багийн гишүүд юу юу судалж мэдэж ирэх талаар ажлын төлөвлөгөө гарган түүнийхээ дагуу судалгаа хийхээр болсон. Өмнөх хичээл дээр сурагчдын цуглуулсан мэдээлэлийг үзэж завсрын тайланд бэлтгэж зөвлөгөө өгсөн.

Хичээлийн эхэнд багш дэлгэцээр “Миний хэнз хурга” дууг дүрс бичлэгээр харуулахад мэддэг сурагчид түүнийг даган дуулж байсан. Бичлэгийг үзэж дууссаны дараа “Юуны тухай дуу вэ?, Ямар ямар төл мал байдаг вэ?, Мал хэзээ төллөдөг” гэх мэт асуултыг тавьж хариулт авсан.

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл:

Багш сурагчдад хандан багууд юу судалж мэдсэнээ бусдадаа тайлагнана. Ингэхдээ: Нэг нь ярьж бусад нь сонсоно дүрмийг баримтлана гэдгийг санууллаа.

Самбарт ангийн сэдвийн тор хадсан байна. Түүнийгээ танилцууллаа.

Багууд сугалаа сугалж дарааллаа тогтоож өөр өөрсдийн судалсны дагуу судалж ирснээ тайлагнана.


Цагаан идээ баг: Багийн ахлагч өөрийн багийн сэдвийн тороо тайлбарлав.

Багийн гишүүд өөр өөрсдийн судалж мэдсэнээ тайлагнав.

Үүнд: бүх төрлийн цагаан идээг биетээр авчирсан байсан. Цагаан идээг хэрхэн яаж боловсруулдаг талаар өөрсдийн судалснаа мэдээлэв.

Цагаан идээний ач холбогдол сэдвээр бяцхан дүр тоглож үзүүлэв.

2 найз уулзаад 1найзын нь шүд өвдсөн байв. Нөгөө найз нь яасныг асуугаад миний шүд ерөөсөө хорхой идээгүй, гэхэд найз нь “Чиний шүд яагаад ийм сайхан эрүүл байгаа юм бэ? Гэсэн. “ Би шүдээ тогтмол фтортой оогоор угаадаг. Мөн ааруул эзгий цагаан идээ иддэг, чихэр идэх дургүй гэлээ.” Мөн 2 сурагч аарц авчирч хээтэй ааруул хэрхэн хийдгийг хэвлэж үзүүлсэн.




Мал маллах сайхан багийнхан:

Багийн гишүүд судалж мэдсэнээ бусад багийнхандаа хандаж тайлагнав. Малын арьс ширийг гэрийн нөхцөлд хэрхэн боловсруулдаг, арьс ширээр ямар, ямар эдлэл хийдэг талаар судалж ирснээ тайлагнав. Арьс ширээр юу юу хийж болохыг биетээр үзүүлж тайлбарлав.

Ашиг шим багийнхан:

Малын мах болон таван хошуу малын ашиг тус, махыг хадгалах нөөцлөх, махаар юу юу хийж болдог тухай мэдээлэл хийсэн. Хиам хийх дараалал тоног төхөөрөмжийн тухай мэдээлэлийг интернэтээс татаж дэлгэцээр үзүүлж тайлбарлав. Борцыг 2 аргаар хатаадгийг бодитоор үзүүлж тайлбар хийлээ.

A close-up photograph of a black fountain pen with gold-colored accents, writing on a document. The pen is positioned diagonally from the top left. The background is a blurred blue and white geometric pattern.

Таван эрдэнэ баг:

Малын ноос ноолуурыг биетээр авчран, ноос савах, эсгий хийх, ноос үсээр ямар ямар эдлэл хийж болохыг мэдээллээ. Сурагч Мөнгөнтуяагийн ээжийг урьж авчран дээс томох, утас ээрэх аргыг биетээр хийж харуулсан нь маш сонирхолтой байлаа.

Багууд тайлангаа тавих явцад багш сурагчдын ахиц өөрчлөлтийг тэмдэглэж байсан. Багш сурагчдыг урмын үг хэлж үнэлэв. Багууд тайлангийн завсраар алжаал тайлах дасгал хийлгэлээ.



Хичээлийн төгсгөл хэсгийн шийдэл:

Багуудын судалсан мэдээлэлээс гол санааг нь сурагчдаар тэмдэглүүлнэ. Багийн сурагчид бусад багийн хийсэн зүйл бүтээлийн үзэсгэлэнг үзэж сонирхов. Үүний дараа нөхдийн санал үнэтэй аргаар бусад багуудыг юу судлах талаар сурагч бүр нэг саналыг том цаасан дээр бичээд бусад багийнхандаа уншиж гардуулж өгөв.

Багш багуудын үйл ажиллагааг дүгнэж цаашид юу судлах талаар зөвлөгөө өгсөн. Дараагийн хичээлд юу судлах талаар баг тус бүр ярилцаж ажлын төлөвлөлтөө гаргаж хичээл дууссан.

Дүгнэлт

Хүүхдийн амьдралд ойр сэдэв байсан учраас хүүхдүүд мэдээлэл, биет материалыг сайн цуглуулж ирсэн байсан. Багийн сурагчид нь мэдээлэлийг олон сувгаар цуглуулан түүнийгээ ярьж тайлагнах чадвар маш сайн байсан. Ангийн сэдвийн тороос багийн торыг үүсгэж багийн гишүүдийн үүргийг хуваарилсан.

Төсөлт ажил хичээлд зочин урьж авчирсан нь сайшаалтай боловч зочноо тодорхой сайн танилцуулж сурагчдын дунд оруулах, ирсэн зочин өөрийн хийх зүйлээ дэлгэрэнгүй сайн тайлбарлах тал дээр хойшид анхаарах

Сурагчдыг тайлан тавьж байхад гарч байгаа мэдэхгүй үг хэллэгийг дор бүр нь тайлбарлаж өгөх хэрэгтэй. Багш сурагчдыг тайлан тавьж байх үед нь чиглүүлэн хөтлөхөд нь анхаарах

Сэдвийн торыг хийхдээ агуулгаа тооцоолон үзэх хэрэгтэй.

Багийн нийт гишүүд бүгд тодорхой үүрэгтэйгээр оролцож тайлагнах, биетээр үзүүлэх, тайлангийн олон хэлбэрийг сонгож тавих

Судалгааны ерөнхий үр дүн

- Сурагчдын хөгжил төлөвшилд бүтээлч, хамтач чанар төлөвшиж, мэдэхгүй зүйлээ мэдэх аргад суралцах гэсэн эрмэлзэлтэй болсон.

- Сурагчид өөртөө итгэлтэй болсноор чөлөөтэй нээлттэй сэтгэж өөрийгөө илэрхийлэх болон илтгэх чадвар нь сайжирсан.

- Мэдээлэлийг олон сувгаар хайж, олсон мэдээлэлдээ боловсруулалт хийж сурсан.

- Багш сурагч эцэг эхийн харилцаа хамтын ажиллагаа өөрчлөгдсөн.

- Багаар хамтарч ажиллах, бусдыг сонсох

- Хүүхэд өөрийгээ эрж хайх нээх, өөрийнхөө тухай бодох, амьдралаас сурах



Хичээлд суусан багш нарын зарим тэмдэглэлээс харуулахад:

- Багш Төгсжаргал” сурагчид их идэвхтэй сайн бэлдсэн байна. Мэдээлэлийг олон талаар олж авсан байна. Бусдыгаа саын соносжж байна.”
- Багш Долгорсүрэн” би өмнө жил 4-р ангид хичээл орж байсан. Тэр үеэс хойш сурагчдын төсөлт ажил хичээлд оролцох оролцоо сайжирч, судалгаа хийх аргаа олсон байна.”
- Тэлмэн сумын сургалтын менежер Янжинлхам “ Энэ хичээлээр сурагчид судалгаа хийж сурсан байна. Судалгаа нь амьдралд ойр, ахуй амьдралтай холбоотой сэдэв байлаа.
- Идэр сумын багш Оюунгэрэл” энэ ангийн сурагчид илтгэх чадвар, мэдээлэл боловсруулах, түгээх чадвар өндөр байна. Төлөвлөгөөг сайн гаргаж сурсан, хариуцах эзэнтэй, төлөвлөгөөний дагуу ажиллаж сурсан сайн талтай.”
- Багш Сайнбаяр “ Би сурагч Энхтогтохыг ажиглалаа. Өмнөх хичээлүүдэд энэ сурагч өөрийгөө илэрхийлэх чадвар сул байсан бол энэ удаад ярих илтгэх чадвар нь илт сайжирсан байна.”

Эндээс харахад сурагчдад ямар өөрчлөлт гарч байгааг харуулж байна.



Цаашид дэвшүүлэх санал

Төсөлт ажил нь хүүхдийг нээж хөгжүүлж чаддаг
бүтээлч сэтгэлгээтэй амьдрах чадварт сургадаг
хичээл учир цаашид бага боловсрол гэлтгүй
дунд ахлах ангийн хичээлийн хөтөлбөрт
оруулж өгөх нь зүйтэй болов уу?

Ном зүй

1. “Төсөлт ажлын арга зүй Зөвлөмж 1,2,3” УБ, 2009
 2. “Багшлахуйн хөгжил. Төсөлт ажлын модуль” УБ 2011
 3. “Үндсэн сургалтын модуль”
 4. www.google.mn О. Пүрэв “Суралцагчийн хөгжил төлөвшил”
 5. “Хичээлд мониторинг хийх” ЖАЙКА 2009
 6. Боловсрол судлал сэтгүүл 2006-2011 он
 7. Д. Эрдэнэчулуун “Хүүхдийг судлах арга зүй” УБ 2010
 8. Байгалмаа. Ч “Багш нарын хөгжлийнхөө хэрэгцээг тодорхойлсон судалгаанд хийсэн анализ” Лавай сэтгүүл УБ, 2004
 9. Ц. Наранцэцэг “Төсөлт ажил цуврал 1” УБ, 2008
-

A close-up, shallow depth-of-field photograph of a black fountain pen with gold-colored accents, resting on a document. The document has some faint, illegible text and a date stamp that appears to say "2012". The background is a soft, out-of-focus blue and white.

**Анхаарал тавьсанд
баярлалаа.**